

**МОНГОЛ УЛСЫН
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
2010 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТОМООХОН АРГА ХЭМЖЭЭНҮҮД,
ХҮРСЭН ҮР ДҮН**

- ❖ ХХЗХ-ны хуралдааны шийдвэрээр сүлжээ хоорондын дотоодын харилцан холболтод газар зүйн ялгаваргүй төлбөрийг 2010 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн мөрдөх, цахилгаан холбооны үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээ хоорондын харилцан холболтын орлого хуваарилах зарчмыг шинэчилсэн болно. 2010 оны 2 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн харилцаа холбооны үйлчилгээний үнэд мөрдөж байгаа хот хоорондын, хотын дотор гэсэн ялгаатай тарифыг ялгаваргүй ижил тарифтай болгож, гэрээнд Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, Мэдээлэл Холбооны сүлжээ ХХК, Мобиком ХХК, Скайтел ХХК, Юнител ХХК, Жи-Мобайл ХХК, МЦХ ХК-ийн ерөнхий захирлууд тус тус гарын үсэг зурсан болно. Үүний үр дүнд өмнө нь газар зүйн байрлалаас ихээхэн зөрвөтэй байсан бvх төрлийн ярианы үйлчилгээ аймаг, хот хоорондын гэж ялгалгvй ижил тvвшинд, түүнчлэн интернетийн үнийг мөн газар зүйн байрлалаас vл хамаарсан ижил үнэ тарифт шилжvүлэн хот, хөдөөгийн мэдээллийн болон тоон хүртээмжийн ялгааг арилгахад чухал алхам болсон. Уг арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсний үр дүнд үр дүнд буюу 2010 оны эхний 9 сарын байдлаар, үүрэн телефон хэрэглэгчдийн хот хоорондын харилцан холболтын ярианы тариф дунджаар 1.7-2.1 дахин хямдарсан бол суурин телефон холбооны хэрэглэгчдийн хот хоорондын ярианы үнэ тариф дунджаар 1.6-2 дахин тус тус хямдруулаад байна.
- ❖ Мэдээлэл Холбооны Сүлжээ ТӨК-ийн интернэтийн үйлчилгээний зориулалтаар хот хоорондын суваг түрээслэх тарифт зохицуулалт хийж, ХХЗХ-ны 2010 оны 1 дүгээр хуралдааны 01 тоот тогтоолоор батлуулан мөрдүүлж байна. Уг тариф батлагдан мөрдөж эхэлснээр хэрэглэгчийн интернэтийн сарын суурь хураамж дунджаар 15.0 хувиар хямдруулснаар хэрэглэгчийн интернэтэд холбогдох хурд нэмэгдэх боломжийг бүрдүүлэв.
- ❖ ХХЗХ-ноос жил бүр холбогдох төр, засгийн байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчид нарын дунд зохион байгуулдаг “Харилцаа холбооны зохицуулалт-2010” форумыг “Бизнесийн орчины шинэтгэл-оновчтой зохицуулалт” сэдвийн дор 2010 оны 5 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулав. Тус форумд тус хорооноос тусгай зөвшөөрөлтэй иргэд, үйлчилгээ эрхлэгчдийг хамруулсан ба нийт орон нутаг, Улаанбаатар хотоос нийтдээ 250 гаруй төлөөлөгч оролцсон болно. Форумыг интернэт, телевиз, шуудангийн 3 дэд салбар хуралдаантайгаар зохион байгуулж, хүрсэн ололтоо дүгнэж, хүндрэлтэй асуудлуудыг хэлэлцэн бизнесийн орчныг шинэчлэх, үр ашигтай зохицуулалт хийхэд шаардлагатай зөвлөмжийг санал нэгтэй оролцогч нараас гаргалаа. Зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган холбогдох арга хэмжээг авч ажиллав.
- ❖ Монгол Улсын Засгийн газраас зарласан “Бизнесийн орчны шинэтгэлийн жил-2010”, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, түүнийг олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль, тогтоомж, дүрэм журам бусад актыг хянан боловсронгуй болгох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын 2010 оны 60 дугаар захирамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газрын ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, ХХЗХ-ноос салбарын үйлчилгээ эрхлэгчдэд үзүүлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа, үйлчилгээг нээлттэй, ил тод, шуурхай болгох, хүнд суртлыг бууруулах зорилгоор олгож байсан нийт

- 42 тусгай зөвшөөрлийн тоог 21 хүртэл цөөрүүлэх саналыг боловсруулан хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.
- ❖ ХХЗХ-ноос 2009 онд орон даяар зарласан “Интернэтийн жил”-ийг 2010 онд үргэлжлүүлэн хөдөө орон нутгийн хэрэглэгчдийг интернэтийн үйлчилгээнд өргөнөөр хамруулах, интернэтийн хэрэглээнд сургах, хот хөдөөгийн үйлчилгээний үнийн ялгааг арилгах арга хэмжээний хүрээнд Дэлхийн банктай хамтран “Сумдад интернетийн үйлчилгээ хүргэх” төслийг боловсруулж, Монгол Улсын Төв, Булган, Дундговь, Өмнөговь, Хөвсгөл, Увс, Өвөрхангай, Завхан аймгийн 34 сумын төвд интернэтийн үйлчилгээ нэвтрүүлэх гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, интернэтийн үйлчилгээ нэвтрүүлэв.
 - ❖ Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, Дэлхийн банктай хамтран 2008 оноос эхлэн хэрэгжүүлсэн “Хөдөөг холбоожуулах хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн-*Universal Access Program Final Workshop*” сэдэвт семинарыг 2010 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулав. Уг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн бүх сумын төвд үүрэн холбооны сүлжээ байгуулж үйлчилгээ хүргэх дэд төсөл, Малчны сүлжээ байгуулан цахилгаан холбооны үйлчилгээ нэвтрүүлэх дэд төсөл, интернэтийн үйлчилгээ нэвтрүүлэх дэд төсөл, харилцаа холбооны бүх нийтийн үйлчилгээг нэвтрүүлэхэд учирч буй тулгамдсан асуудлууд, хүрсэн үр дүн, цаашдын зорилтын талаар хэлэлцсэн ба ХХЗХ, МШХХТГ, Дэлхийн банк, хөдөө орон нутгийн төлөөлөл зэрэг 150 гаруй зочид, төлөөлөгчид оролцлоо. Дэлхийн банкнаас Монгол Улсад хэрэгжсэн энэхүү хөдөөгийн холбооны төсөл нь дэлхийн бусад улс, орнуудад хэрэгжсэн төслүүдээс шилдэг, жишиг болсон арга хэмжээ бөгөөд төслийг хэрэгжүүлсэн ХХЗХ-ны үйл ажиллагааг өндөр үнэлэн дүгнэлээ.
 - ❖ Үүрэн холбооны 3 дахь үе буюу 3G технологи, үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлснээр үүрэн холбооны салбарт дэвшил гарч, мэдээлэл холбооны орчин үеийн шинэ төрлийн үйлчилгээ болох өргөн зурвас, интернэтийн утасгүй холбооны үйлчилгээ, хэрэглээг хэрэглэгчид хүртэх боломжийг бүрдүүлэв. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч оператор компаниуд 3G технологи нэвтрүүлэх техникийн шилжилт, шинэчлэлтийг 2010 онд амжилттай хэрэгжүүлэн хамрах хүрээгээ нэмэгдүүлэх арга хэмжээг авснаар Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг 20 гаруй хот, аймгийн төв, томоохон суурин газарт тус тус нэвтрүүлээд байна.
 - ❖ Сансарын хиймэл дагуул ашиглан улс орон даяар олон сувгийн телевизийн өргөн нэвтрүүлгийн тоон технологиор дамжуулж эхэлснээр хөдөө орон нутаг, малчид Монгол улсын бүх сувгийн телевизийн өргөн нэвтрүүлгийг чанарын өндөр түвшинд үзэх техникийн боломжийг бүрдүүлээд байна.
 - ❖ Үндэсний радио давтамжийн хяналтыг шинэчлэх төслийг бүрэн хэрэгжүүлж, орчин үеийн радио давтамжийн хяналт, хэмжилтийн тоноглол бүхий суурин, явуулын, зөөврийн тоног төхөөрөмжтэй Үндэсний радио давтамжийн хяналтын тогтолцоог анх удаа Монгол Улсад бий болгов. Энэхүү арга хэмжээний үр дүнд Монгол Улсад ашиглагдаж буй давтамжийн зурвасыг бүрэн хэмжээгээр хянах боломжийг бүрдүүллээ.
 - ❖ ХХЗХ-ноос санаачлан боловсруулж, Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн “Монгол Улсын радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн сүлжээг тоон технологид шилжүүлэх” үндэсний хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулж, МШХХТГ болон Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 27-ний өдрийн 275 дугаар тогтоолоор батлуулав. Хөтөлбөрт зааснаар Монгол Улс нь 2014 оны 7 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн тоон телевиз, радиогийн сүлжээнд бүрэн шилжих, радио телевизийн зохицуулалтын үйл ажиллагааг цогцоор нь хэрэгжүүлэх боломж бүрдээд байгаа болно. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах

- ажлын хэсгийг ХХЗХ-ны Даргын 2010 оны 211 тоот тушаалаар байгуулж, нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна.
- ❖ ХХЗХ-ны хуралдаанаар “Хэлэлцүүлэг хийх журам” хэлэлцүүлэн батлуулж, зохицуулалтын дүрэм, журмыг олон нийт, үйлчилгээ эрхлэгч нартай хамтран хэлэлцэх, байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох, аливаа зохицуулалтын баримт бичиг, дүрэм журмын төслийг хэлэлцүүлэн холбогдох саналыг авч тусгах зарчимд шилжүүлэв.
 - ❖ Монгол Улсын телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор холбогдох судалгааны үндсэн дээр асуудлыг боловсруулж, Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 27-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн “Телевиз, радиогийн зохицуулалтын талаар баримтлах чиглэл батлах тухай” Засгийн газрын 276 тоот тогтоолыг гаргуулсан болно. Тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор телевизийн зохицуулалт, радиогийн зохицуулалтын ерөнхий журмын төслийг тус тус боловсруулан 2010 оны 12 дугаар сард 2 удаа хэлэлцүүлэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дунд тус хорооноос зохион байгуулав.
 - ❖ ХХЗХ-ноос 2010 онд хэрэгжүүлэх зорилт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, салбарын зохицуулалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, үйл ажиллагаагаа сурталчилах, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах зорилгоор “Харилцаа холбооны зохицуулалт-2010” форум, “Тоон телевизийн туршлага–хөгжлийн чиг хандлага”, “Шуурхай ажиллагааны радио давтамжийн зурвасын хуваарилалт, ашиглалт”, “Хөдөөг холбоожуулах хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”, “Монгол Улсын өргөн зурвасын сүлжээний стратеги, судалгааны үр дүн”, “Хэвлэл мэдээллийн өөрийгөө зохицуулах механизм, Ёс зүйн зарчим”, “Шуудангийн технологийн стандартын мөрдөлт, гаалийн бүрдүүлэлт”, “Радио давтамжийн ашиглалт үйлчилгээний төлбөрийн хэмжээний тухай журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”, “Монголын ФМ радиогийн хөгжлийн чиг хандлага” сургалт семинар, “Харилцаа холбооны сүлжээгээр онлайн контентийн үйлчилгээ эрхлэхэд баримтлах журам”, “Мобайл контентийн үйлчилгээ эрхлэхэд баримтлах журам”, “Вэб сайтын үйлчилгээ эрхлэхэд баримтлах түр журам”, “Радио телевизийн зохицуулалтын ерөнхий журам”-ын төсөл зэрэг сэдвээр 20 гаруй сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт, сургалт семинарыг тус тус зохион байгуулсан нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид, иргэдэд үйл ажиллагаагаа сурталчилах, оролцоог хангах, хамтран ажиллах, зохицуулалтын үйл ажиллагаандаа холбогдох зөвлөмж, саналыг нь тусгах, үйл ажиллагаа уялдуулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.
 - ❖ 2010 онд Харилцаа холбооны зохицуулах хорооны ээлжит 10, ээлжит бус 3 удаагийн хуралдаанаар мэдээлэл, харилцаа холбоо, радио телевиз, шуудангийн салбарын зохицуулалтыг боловсронгуй болгох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зохицуулалтын холбогдох дүрэм, журам батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхцөл шаардлага боловсруулах, тусгай зөвшөөрөл сунгах, олгох, цуцлах зэрэг нийт 60 гаруй дүгнэлт, асуудлыг боловсруулан хэлэлцүүлж нийтдээ хуралдааны 48 тогтоол, 16 тэмдэглэлийг тус тус гарган шийдвэрлэв. Хорооны хуралдааны тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэв.

ЭРХ ЗҮЙ, МЭДЭЭЛЭЛ, ЗАХИРГААНЫ АЛБА
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2010.12.30